

Баян-Өлгий аймаг дахь Төрийн аудитын газар



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Баян-Өлгий аймгийн Нийгмийн халамжийн сан /Орон нутаг/-ийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Аудитын код: **БӨА-2022/188/НА-СТА-ТШЗ**

Цахим хуудас: www.audit.mn Өлгий хот 2022 он	Баян-Өлгий аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор: М.Хуанган Утас: 70422954 Цахим хаяг: Khuanganm@audit.gov.mn Аудитын менежер: Х.Женисбек Утас: 70422930 Цахим хаяг: jenisbekh@audit.gov.mn Ахлах аудитор: Х.Манаргүл Утас: 95429524 Цахим хаяг: manargulx@audit.gov.mn
---	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

1. Аудитын санал дүгнэлт	Error! Bookmark not defined.
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	4
3. Аудитын тайлан.....	7
3.1 Ерөнхий зүйл.....	7
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт	7
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	7
3.4 Материаллаг байдал	8
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга.....	8
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв.....	8
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг.....	9
3.8 Аудитын гол асуудал	9
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	9
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	10
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	10
4. Аудитын илрүүлэлт	10
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл	10

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар

Төсвийн захирагч



**БАЯН-ӨЛГИЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

83129 Өмнөд, Баян-Өлгий аймаг,
Утас/Факс: (976) 7042-2954
E-mail: bayanulgi@audit.gov.mn

БАЯН-ӨЛГИЙ АЙМГИЙН ХӨДӨЛМӨР,
ХАЛАМЖ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ГАЗРЫН
ДАРГЫН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН
ГҮЙЦЭТГЭГЧ А.ГАЛИЯ ТАНАА

2022.02.17 № 66
танай _____-ны № _____-т

АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу аймгийн Баян-Өлгий аймгийн Нийгмийн халамжийн сан /Орон нутаг/-ийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Баян-Өлгий аймгийн Нийгмийн халамжийн сан /Орон нутаг /-ийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх

үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  М.ХУАНГАН

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>7,873.86</u>	=
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	7,873.86	-
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	7,873.86	-
3121	Төгрөг	7,873.86	-
31213	Арилжааны банк дахь харилцах	7,873.86	-
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>7,873.86</u>	=
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>7,873.86</u>	=
51	Засгийн газрын хувь оролцоо	7,873.86	-
512	Хуримтлагдсан үр дүн	7,873.86	-
51210	Өмнөх үеийн үр дүн	2,442,870.53	7,873.86
51220	Тайлант үеийн үр дүн	(2,434,996.67)	(7,873.86)
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>7,873.86</u>	=

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	153,025,003.33	168,410,000.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	37,003.33	-
120	Нийтлэг татварын бус орлого	37,003.33	-
120002	Хүүгийн орлого	37,003.33	-
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	152,988,000.00	168,410,000.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	152,988,000.00	168,410,000.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	152,988,000.00	168,410,000.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	155,460,000.00	168,417,873.86
21	УРСГАЛ ЗАРДАЛ	155,460,000.00	168,417,873.86
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	10,000.00	-
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	10,000.00	-
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	10,000.00	-
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	155,450,000.00	168,417,873.86
2132	Бусад урсгал шилжүүлэг	155,450,000.00	166,010,000.00
213203	Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж	155,450,000.00	166,010,000.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	-	2,407,873.86
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	-	2,407,873.86
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	<u>(2,434,996.67)</u>	<u>(7,873.86)</u>
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	<u>(2,434,996.67)</u>	<u>(7,873.86)</u>

2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
D01	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	7,873.86	7,873.86
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт		-
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	7,873.86	7,873.86
D08	Тайлант үеийн үр дүн	(7,873.86)	7,873.86
D09	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	-	-

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	<u>153,025,003.33</u>	<u>168,410,000.00</u>
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	37,003.33	-
120	Нийтлэг татварын бус орлого	37,003.33	-
120002	Хүүгийн орлого	37,003.33	-
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	152,988,000.00	168,410,000.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	152,988,000.00	168,410,000.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	152,988,000.00	168,410,000.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	<u>155,460,000.00</u>	<u>168,417,873.86</u>
21	УРСГАЛ ЗАРДАЛ	155,460,000.00	168,417,873.86
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	10,000.00	-
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	10,000.00	-
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	10,000.00	
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	155,450,000.00	168,417,873.86
2132	Бусад урсгал шилжүүлэг	155,450,000.00	166,010,000.00
213203	Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж	155,450,000.00	166,010,000.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	-	2,407,873.86
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	-	2,407,873.86
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	<u>(2,434,996.67)</u>	<u>(7,873.86)</u>
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	(2,434,996.67)	(7,873.86)
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	2,442,870.53	7,873.86
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	7,873.86	(0.00)

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	168,410,000.00	166,010,000.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	168,410,000.00	166,010,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	168,410,000.00	166,010,000.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	168,410,000.00	166,010,000.00
213203	Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж	168,410,000.00	166,010,000.00
13	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	168,410,000.00	168,410,000.00
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	168,410,000.00	168,410,000.00
132001	Орон нутгийн төсвөөс	168,410,000.00	168,410,000.00

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Баян-Өлгий аймгийн Нийгмийн халамжийн сан /Орон нутаг/-ийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Баян-Өлгий аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор Х.Манаргүл гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Х.Женисбек, дарга, тэргүүлэх аудитор М.Хуанган нар тус тус хэрэгжүүлсэн.

Аймгийн Нийгмийн халамжийн сан / Орон нутаг /-ийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Баян-Өлгий аймаг дахь төрийн аудитын газарт 2022 оны 01 дүгээр сарын 24-ны өдрийн 1/30 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Аймгийн Нийгмийн халамжийн сан /Орон нутаг/-ийн зорилго нь: Нийгмийн халамж, хамгааллын бодлого, хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангуулан, нийгэм, эдийн засгийн үндсэн чиглэл, мөрийн хөтөлбөр, төлөвлөлтөд нийцсэн мэдээллийн бодит бүтээгдэхүүн, үйлчилгээг нийлүүлэх

Дээрх зорилгынхоо хүрээнд дараах зорилтыг тавьж ажилласан байна.Үүнд:

Салбарын хууль тогтоомж, бодлого, хөтөлбөр, дүрэм, журмын хэрэгжилтийг зохион байгуулах ажлын уялдаа холбоог хангах, төрийн захиргааны удирдлагын манлайлал, хүний нөөцийн чадавхийг бэхжүүлэх, төрийн үйлчилгээний чанарыг сайжруулах замаар үйл ажиллагааны үр нөлөө, үр ашгийг тасралтгүй дээшлүүлэх, дотоод, гадаад хамтын ажиллагааг хөгжүүлэх

Нийгмийн халамжийн тухай, Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай, Ахмад настны тухай хуулиуд болон бусад холбогдох хууль тогтоомжийн хэрэгжилтийг нутаг дэвсгэрийн хэмжээнд зохион байгуулах чиг үүрэг бүхий байгууллага юм.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Аймгийн Нийгмийн халамжийн сан /Орон нутаг/-д дотоод аудитын нэгжгүй бөгөөд тус байгууллагын захиргаа хяналтын хэлтсээс 2 мэргэжилтэн хяналт тавьж ажилласан байна. Тайлант онд ямар нэгэн шалгалт хийгдээгүй байна.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр

санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Аймгийн Нийгмийн халамжийн сан /Орон нутаг/-ийн 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт хөрөнгийн сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл “дунд” гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 2 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны нийт зардлын 155.5 сая төгрөгөөс 2 хувиар буюу 3.1 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 80 хувиар буюу 2.5 сая төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Аймгийн Нийгмийн халамжийн сан /Орон нутаг/-ийн 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 7.9 мянган төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	7.9	-	(7.9)
Нийт хөрөнгө	7.9	-	(7.9)
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	7.9	-	(7.9)
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	7.9	-	(7.9)

Мөнгөн хөрөнгийн дансны үлдэгдэл оны эхнээс 7.9 мянган төгрөгөөр буурсан байна. Энэ нь арилжааны банкин дахь харилцах дансны хүүгийн үлдэгдэлийг төвлөрүүлсэнтэй холбоотой байна. Оны эхэн ба эцэст өглөггүй байна.

Засгийн газрын хувь оролцоо оны эцэст дансны үлдэгдэлгүй гарч өмнөх оны үлдэгдлээс 7.9 мянган төгрөгөөр буурсан нь тайлант үеийн үр дүнтэй холбоотой байна.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Аймгийн Нийгмийн халамжийн сан /Орон нутаг /-ийн 2021 оны төсвийг 168.4 сая төгрөгөөр баталсан ба тодотголоор өөрчлөлт ороогүй байна.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Гүйцэтгэлээр орон нутгийн төсвөөс 168.4 сая төгрөгийн санхүүжилт авч өмнөх оны дансны үлдэгдлээс 2.5 сая төгрөгийн, бусад болон хүүгийн орлогоос 0.008 сая төгрөгийн бүгд 168.408 сая төгрөгийн орлого бүрдүүлжээ.

Үүнээс 142.6 сая төгрөгийг онцгой тохиолдлын болон амьжиргааг дэмжих мөнгөн тэтгэмжид, 23.4 сая төгрөгийг олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээ, нийт 166.0 сая төгрөгийг зарцуулж, төсвийн хэмнэлт болох 2.4 сая төгрөгийг төсөвт төвлөрүүлсэн байна.

Сангийн зардлын нийт гүйцэтгэл 99.8 хувьтай гарсан байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.6.3 Нэмэлт төсөв

Нийгмийн халамжийн сангийн /Орон нутаг/-т нэмэлт төсөв хуваарилагддаггүй байна.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Аймгийн Нийгмийн халамжийн сан /Орон нутаг/-ийн 2021 оны санхүүгийн тайланд холбогдох бүх мэдээллийг толилуулж, тодруулсан байна.

АОУС 706.10-д заасан бусад асуудлын хэсэгт тусгахаар аудитын хамрах хүрээний хязгаарлалтын улмаас аудитын хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй байдал үүсээгүй болно.

3.8 Аудитын гол асуудал

АОУС 701.8-д тодорхойлсон аудитын гол асуудлын хүрээнд 2021 оны санхүүгийн тайланд үлэмж нөлөө үзүүлэх материаллаг буруу илэрхийлэл гараагүй байна.

Материаллаг буруу тайлагналын өндөр үнэлэгдсэн эрсдэл, нөлөө бүхий эрсдэл, удирдлагын үлэмж хэмжээний шийдэл орсон асуудал, тайлант хугацаанд нөлөө бүхий ажил гүйлгээ гараагүй байна.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1, 3.1.2-т хамаарах төсөвт байгууллага нь тус хуулийн 6 дугаар зүйлийн 6.1, 6.4-т /шилэн дансны мэдээлэл/ тус тус заасан мэдээллийг хуульд заасан хугацаанд ил тод мэдээлэх зохицуулалттай.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан дараах 10 төрлийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Аймгийн Нийгмийн халамжийн сан /орон нутаг/ нь 2021 онд нийт 168,4 сая төгрөгийн 107 мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулахаас 168.4 сая төгрөгийн 107 мэдээллийг хугацаандаа оруулсан боловч 67 мэдээллийг тодорхой шалтгаанаар хугацаа хоцорож байршуулсан байна. Цалингийн зардлаас бусад 5.0 сая төгрөгөөс дээш дүнтэй 4 гүйлгээг байршуулсан байна. Өр, авлага гараагүй байна.

3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн, батлагдсан төсвийн зарцуулалт нь төсвийн тухай хууль тогтоомжийг холбогдох заалтуудтай байна гэж дүгнэлээ.

3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны аудитаар шилэн данстай холбоотой зөвлөмж өгөгдөөгүй байна.

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Анхаарал татахуйц чухал асуудал гараагүй болно. Харин цаг хугацааны хязгаарлагдмал байдлаас шалтгаалж халамжийн тэтгэвэр, тэтгэмжийн зарцуулалтын тооцоог бүрэн шалгах боломжгүй тул гүйцэтгэлийн шалгалтаар дэлгэрэнгүй шалгах нь зүйтэй байна.

4. Аудитын илрүүлэлт

Аудитаар алдаа зөрчил гараагүй болно.

4.1 Залруулсан алдаа

Залруулсан алдаа байхгүй

4.2 Төлбөрийн акт

Тогтоосон төлбөрийн акт байхгүй

4.3 Албан шаардлага

Албан шаардлага байхгүй

4.4 Зөвлөмж

Аудитаар зөвлөмж өгөгдөөгүй.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/сая төгрөгөөр/

Д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн